



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 8/87

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ховд аймгийн 2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.34. Жаргалант сумын тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Даваасамбуу (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Ц.Бат-Эрдэнэ (Ховд Жаргалант ОНӨААТҮК-ний менежер)

Э.Отгоншар (Төрийн бус байгууллагын төлөөлөл)

Б.Батзол (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг: Б.Болор-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч)

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг үнэлгээний хорооны дарга (Ц.Даваасамбуу)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Б.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.САНДАГСҮРЭН



8499903 0460
Tush A/87 Ba